

ДСЦТС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2025.04.30

Цаг: 14:00-15:45

Байршил: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо "Хасвуу Плаза"-гийн хурлын танхимд зохион байгуулагдав.

Хурлын дарга: Ц.Баярбаатар

Тооллогын комиссын дарга: Г.Бэхбат

Тооллогын комиссын гишүүн, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга: М.Баярманла

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн ирц: 100 хувь

Саналын эрхтэй хувьцааны тоо 10,385,116

Хуралд Эвиденс аудитын төлөөлөл болон ТУЗ-ийн 2024 онд томилогдсон гишүүдээс Б.Эрдэнэбилэг гишүүгээс бусад нь оролцов.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах;
 3. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох;
 4. Компанийн ТУЗ-ийн 2025-2026 оны цалин урамшуулал болон зардлыг батлах.
-

Хэлэлцэх асуудал нэг

Ц.Баярбаатар тус компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийн хамт танилцуулав.

Тогтоолын төсөл: Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн тайланг хэлэлцэн батлах

Зөвшөөрсөн: 100 хувь буюу нийт саналын эрхтэй хувьцаа: 10,385,116

Татгалзсан: 0

Түдгэлзсэн: 0

Хэлэлцэх асуудал хоёр

Ц. Баярбаатар компанийн 2025 оны үйл ажиллагааны үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн тогтоолыг танилцуулав.

Хэлэлцэх асуудал гурав

Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох

М.Баярманла компанийн ердийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийг танилцуулав.

Кумулятив аргаар ердийн болон хараат бус гишүүдийг сонгох зааварчилгааг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Санал хураалтын дүн:

Хараат бус гишүүд:

(i) Галсангийн Бэхбатад өгсөн саналын эрх: 9,865,860

(ii) Жамсрандоржийн Дэлгэрсайханд өгсөн саналын эрх: 9,865,860

(iii) Нямдаваагийн Монсорт өгсөн саналын эрх: 9,865,860

(vi) Цэндсүрэнгийн баярбаатартт өгсөн саналын эрх: 9,865,860

Ердийн гишүүд:

(v) Нүдэнгийн Эрдэнэбатад өгсөн эрх: 9,865,860

(vi) Цэнгэлийн Хангайд өгсөн эрх: 9,865,860

(vii) Түмэнжаргалын Энхмэндэд өгсөн эрх: 9,865,860

(viii) Самдангийн Нэргүйд өгсөн эрх: 9,865,860

(ix) Буянзаяагийн Эрдэнэбилэгт өгсөн эрх: 9,865,860

Нэр дэвшигчид ТУЗ-ийн гишүүдээр сонгогдсон болохыг тэмдэглэв.

Хэлэлцэх асуудал дөрөв

Компанийн ТУЗ-ийн гишүүдийн 2025-2026 оны цалин урамшуулал болох зардлыг батлах

Тогтоолын төслийг танилцуулав.

Санал хураалтын дүн:


Зөвшөөрсөн: 100 хувь буюу нийт саналын эрхтэй хувьцаа 10,385,116

Татгалзсан: 0

Түдгэлзсэн: 0

Хурлын дарга хуралд оролцогсдод талархал илэрхийлснээр хурал өндөрлөв.


Тэмдэглэл хөтөлсөн Тооллогын комиссын гишүүн бөгөөд Нарийн бичгийн дарга:


М.Баярманла

Танилцсан Хурлын дарга:


Ц.Баярбаатар

Тооллогын комиссын дарга:


Г.Бэхбат

